

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ РЕАЛИСТ ОНОЛ БА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ: ХУВЬСАЛ ӨӨРЧЛӨЛТ

*С.Дашцэвэл**

XX зууны эхээр олон улсын бодлогын хэд хэдэн онол гарч ирсэн.¹ Түүний нэг гол онол нь реалист онол билээ. Реалист онол нь хүйтэн дайны жилүүдэд дэлхийн ихэнхи улс орны гадаад бодлогын зонхилох онол болжээ.

Америкийн улс төр судлаач Hans Morgenthau реалист онолын эцэг гэгддэг бөгөөд түүний бичсэн “Politics Among Nations” (1948) бүтээл реалист онолын баттай үндэс суурийг тавьсан аж.

Реализм нь дэлхийн хоёр дайны хооронд хүчтэй хөгжиж идеализмийн сул талтай холбоотой нийгмийн сэтгэлгээнд тулгуурлан гарч ирсэн онол юм. Реалист онолын үүднээс үзвэл Олон улсын харилцааны зөрчлийг шийдвэрлэхэд эрх мэдэл бүхий бие даасан хамгийн чухал нэгж нь Үндэстэн-улсууд (Nation-states) ажээ. Эдгээр нь үндэсний ашиг сонирхлын үүднээс олон улсын харилцаанд гол оролцогч бөгөөд туйлын зорилго нь дайсагнасан эмх замбраагүй орчинд аюулгүй байх явдал юм. Тийм учраас юуны урьд үндэсний аюулгүй байдлаа бататган бэхжүүлэхэд хангалттай хүч боломжтой байхыг хүсдэг. Энэ нь чухамдаа бусдад найдах биш өөрийн хүчинд тулгуурлах, зөвхөн өөрийн чадалд найдах үзлийг чухалчилахад хүргэжээ. Энэ онолын үүднээс бол үндэстэн улс нь алив амьд амьтаны төрөлх араншин болох эрх мэдлийн төлөөх өрсөлдөөний шинжийг өөртөө агуулсан байдаг ажээ. Тийм ч учраас үндэсний эрх ашиг бүхнээс дээгүүр тавигдаж үзэл санаа, ёс суртахууны хэм хэмжээ, үнэлэмж хоёрдугаарт тавигдах явдал олон улсын практикт бишгүй гардаг ажээ.

“Улс хоорондын бодлого нь эрх мэдлийн төлөөх тэмцэл бөгөөд хэн хүчтэй нь эрх мэдэлтэй байна, тэр нь алив аюулаас ангид байж эрх чөлөөтэй, дэвжин дээшлэх нөхцөлөөр хангагдана” хэмээн Х. Morgenthau бичжээ.²

* С.Дашцэвэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Нэг үгээр хэлбэл реалистууд Олон улсын байгууллага ба хууль дүрмэнд хэт найдаж түүнд өөрийнхөө аюулгүй байдлыг даатгаж болохгүй гэсэн гүн бат итгэлтэй учир бие биедээ итгэх итгэл алдарч, хүч чаллаа зузаатгах байнгын тэмүүлэлтэй байв. Үүнээс үүдэн зэвсэглэлээр хөөцөлдөх гинжин урвалд өөрийн эрхгүй орж байлаа. Ийм нөхцөлд олон улсын тогтвортой байдлыг хангах гол арга нь хүчний тэнцвэрийг /Balance of Power/ бий болгох явдал байв. Өөрөөр хэлбэл олон улсын тогтвортой байдал гэдэг нь хүчний тэнцвэрийг хадгалж чалсаны үр дүн болж байв.

Дэлхийн II дайны үеийн олон улсын харилцаан дахь хүчирхийлэл, түүний дараах хоёр туйлт дайсагнасан харилцаа, цөмийн зэвсэглэл, хүйтэн дайны үеийн хурцалмал байллууд нь олон улсын харилцааны *реалист* онолын тухай итгэл үнэмшилийг улам лавшруулж байв.

Гэвч 70-аад оны эхээр дэлхийн улс төрийн байдалд зарим өөрчлөлт ажиглагдав. Хурцалмал байдлын хажуугаар намжмал байдлын уур амьсгал (тухайлбал хамтран зөвлөх, зөвшилцөх, зэвсэг хорогдуулах зэрэг) Европ дахинд бий болж эхэлжээ. Үүний зэрэгцээ олон улсын институтуудын үүрэг роль нэмэгдэв. Ялангуяа Америкийн гадаад бодлогын стратегид зарим өөрчлөлт гарч дэлхийн коммунизмын давшилыг “тогтоон барих” бодлого нь Энэтхэг-Хятадын хойгт баахан бүтэлгүйтэж байв.

Энэ үед реалист онолыг дайран шүүмжлэгчид гарч ирсэн тул олон улсын бодит амьдралд илүү нийцсэн *неореализм* гарч ирсэн түүхтэй. Эхэн үеийн реалистууд Nation-state-ийг Олон улсын харилцаанд гол оролцогчийг нь хувьд ихээхэн анхаарч түүний үүрэг роль ,зорилгодоо хүрэх арга замыг тодорхойлоход чиглэж байсан бол *неореалистууд* дэлхийн бодлогыг Олон улсын харилцааны системийг нь хувьд бүтэц талаас нь онцлон анхаарч үзэл бодлоо үндэслэх болжээ.

Тэд үзэхдээ дэлхий ертөнцөд нэгдсэн удирдлага бий болж төлөвшөөгүй, олон улсын хууль эрх бүрэн үйлчилж чадахгүй байгаа, мөн Nation-state бүрийн хүч бололцоо харилцан адилгүй зэрэг олон улсын харилцааны өнөөгийн онцлог шинж улс орон бүрийн гадаад бодлогын шийдвэрт хүчтэй нөлөөлж байлгийг онцлон тэмдэглэж байна.³ Тийм учраас Nation State-ийн бодлого хэрхэн яаж хэрэгжих бололцоо нь олон улсын системээс ихээхэн хамааралтайг анхаарах болжээ. Гэхдээ неореалистууд мөн л хүч

чадлын /Power/ факторыг чухалчилан үздэг бөгөөд олон улсын тогтвортой байдал болон хурцадмал байдлын үе дэх хүчний тэнцвэрийн тухай үзэл бодол чухал байр суурьтай ажээ.

Эдүгээ хүйтэн дайн төгсч, мэдээллийн хувьсгал гүнзгийрч, дэлхий ертөнцийн харилцан хамаарал ихсэх явцтай зэрэгцэн ,гадаад бодлого ,олон улсын харилцаанд хамааралтай зарим ойлголт өөрчлөгдөж байна.

Юуны өмнө хүчирхэг улс гэдгийн хэмжүүрийг цэргийн гэхээсээ эдийн засаг, дэвшилт шинэ технологтой холбон ойлгох боллоо. Алив улс гүрэн хөгжлийн асуудалд илүү анхаарч гадаад бодлогын түрэмгий шинж чанар багасч батлан хамгаалах стаус кво шинж чанар нэмэгдэв.Үүнтэй уялдан олон улсын харилцааны зарчим зорилгод ч өөрчлөлт орж эхлэв.Хүчний тэнцвэр гэхээсээ ашиг сонирхолын тэнцвэр дээр үндэслэсэн гадаад бодлогыг хэрэгжүүлэх болов. Ялангуяа аюулгүй байдлын агуулга шинж чанар улам баяжин өөрчлөгдөж байна.Алив улсын аюулгүй байдалд заналхийлэгч хүчин зүйл нь тэр улсын дотоодод буюу түүний тогтвортой байдал дотор нь ихэнхдээ байдаг ажээ. Чухамхүү энэ нь бусад улсын аюулгүй байдалд нөлөөлж олон улсын шинжтэй болдогийг урьд төдийлөн анзаардаггүй байсан аж. Тийм учраас нэг улсын доторх хүний аюулгүй байдалтай холбоотой эдийн засгийн аюулгүй байдал,эрчим хүчний аюулгүй байдал,хүнсний аюулгүй байдал,байгал орчны аюулгүй байдал зэргийг нэн анхаарах болов.Эдийн засгийн хоцрогдол,шашин омгийн мөргөлдөөнөөс авхуулаад олон улсын терроризм,хар тамхины наймаа,хууль бус цагаачлал хүртэл бага жижиг гэхгүй бүх асуудал эдүгээ үндэсний болон олон улсын аюулгүй байдалд холбогдох болжээ.

Энэ бүхэнтэй уялдан орчин үед аюулгүй байдлыг цогцолбороор шийдэх үзэл санаа бий болж үүнийг дэлхий нийтээр Comprehensive Security (Иж бүрэн аюулгүй байдал) хэмээн нэрлэж заншжээ.4./ Нөгөө талаар дэлхий ертөнц бие биенээс үлэмж хамааралтай болж нэг улсын аюулгүй байдал нөгөө улсын аюулгүй байдлаар нөхцөлдөх боллоо.Үүнтэй уялдан олон улсын бодлогын салбарт улс орнууд хүчний тэнцвэрт түшиглэсэн бус ашиг сонирхлын тэнцвэрт тулгуурласан хамтын хүчин чармайлтаар үндэсний аюулгүй байдлаа хамгаалахаас өөр аргагүй болоод байна.Тэрхүү хамтын чармайлтын шинж чанар ч бидний хуучин ойлголтоос өөр болж байна. Тухайлбал бидний ярьж, зорьж

байсан Collective Security-ийн оронд Cooperative Security хэмээх шинэ ойлголт гарч ирлээ. Collective Security нь аль нэг дайсны (тэр дайсан нь илэрч гарч ирээгүй байлаа ч гэсэн) эсрэг чиглэсэн шинжтэй эвсэл бүлэглэл байгуулан өөрсдийн аюулгүй байдлыг хамтын хүчээр хамгаалах үндсэндээ мөн л хүчний тэнцвэр бий болгох үзэл санаа байлаа. Харин Cooperative Security гэдэг нь аль нэгийн эсрэг чиглэсэн биш бүгдээр бие биенийхээ аюулгүй байдалд санаа тавьж аюулгүй байдлаа нэгдсэн байдлаар хамгаалахад чиглэсэн үзэл санаа юм. Cooperative Security –ийн тухай ойлголт 1980-аад оны сүүлчээр гарчээ. Энэ тухай анхны дэлгэрэнгүй тайлбар хийсэн хүн бол АНУ-ын Brooking Institute-ийн эрдэмтэн John Steinbruner ажээ.⁵ 1990-1993 онд Канадын засгийн газар Умард Номхон далайн хамтын аюулгүйн системийн тухай судалгааны төслийг санхүүжүүлж Cooperative Security-ийн тухай санал солилцох зөвөлгөөнийг хийлэгсэн нь уламжлалт ба уламжлалт бус аюулгүйн асуудлуудыг улам дэлгэрэнгүй судлах боломж олгов. Энэ нь хүйтэн дайны дараах аюулгүй байдлын асуудлыг олон талаас нь судлаж шинэ ойлголтонд хүрхэд чухал нөхцөлийг бүрдүүлсэн бйана. Энэ үеэс бүс нутгийн Cooperative Security-ийн тухай шинэ ойлголт бүрэлдэн бий болжээ. Юуны өмнө хоёр туйлт ертөнцийн бие биентэйгээ сөргөлдөж, хүчний тэнцвэрт түшиглэсэн хүйтэн дайны үеийн аюулгүй байдлын тухай ойлголтыг шинэ үзэл санаагаар сольж шинчлэх явдал гол зорилго нь байв. Түүний үзэл санааны гол цөм нь бүс нутгийн бүх улс орнуудын хүрээнд харилцан санал солилцож *итгэлцэлийг бэхжүүлэх, дипломатын аргаар урьдчилан сэргийлэх/PD/*, зохистой аргаар *мөргөлдөөнийг шийдвэрлэх* гэсэн гурван үе шатыг дамжин аюулгүй байдлаа нэгдсэн чармайлтаар хамгаалах явдал юм.⁶

Канад, АНУ, Австралид анх бүрэлдэн буй болсон энэ ойлголтыг АСЕАН-ы Гадаад Хэргийн сайд нарын уулзалтанд 1993 онд Австралийн Гадаад Хэргийн сайд асан G. Evans танилцуулсан байдаг. Ер нь энэхүү ойлголтыг АСЕАН-ы орнууд Камбожийн асуудлыг шийдэх явцад анх хүлээн авч уг асуудлыг шийдэх үзэл баримтлалын үндэс нь болсон хэмээн Канадын эрдэмтэн Pierre Lizee, Sorpong Peou нар үзжээ.⁷

Чухамхүү энэ үзэл санааны дагуу Зүүн Өмнөд Азийн Холбоо (АСЕАН)-ны АРФ (Asean Regional Forum) үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. АРФ-д одоо Ази Номхон Далайн 22 улс

нэгдэж бүс нутгийн аюулгүй байдлын асуудлыг хэлэлцдэг чухал үйл явц болоод байна. Cooperative Security-ийн үзэл санаа улам баяжан гүнзгийрхэд АСЕАН-ы Аюулгүйн Чуулган, CSCAP-ын албан ба албан бус сувгууд түүний судалгаа үнэтэй хувь нэмрээ оруулж байна/.

Эдүгээ аливаа улс гүрэн бүс нутгийн дотоод гадаад аюулгүй байдлын асуудлыг нягт шүтэлцээ холбоонд нь авч үзсэн Comprehensive Security- Cooperative Security-ийн ойлголтыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч үндэсний аюулгүй байдалдаа үндсэн баримжаа болгох болжээ.

Энэ бүхнээс үзвэл олон улсын системийн болон дэлхийн бодлогын мөн чанар нь хүч чадал хийгээд эрх мэдлийн төлөөх өрсөлдөөн мөн мэт боловч нөгөө талд нь оршин тогтнох, өөрийгөө авран хамгаалахын төлөөх хамтын ажиллагаа бас мөн юм. Орчин үед энэхүү хамтын хүчээр шийдэх олон чухал асуудал бий болсон нь өөрөөр хэлбэл, бие биенээс улам бүр хамааралтай болсон нь өрсөлдөөнийг үгүй болгохгүй ч гэсэн эвсэлдээнийг чухалчлах хүн төрөлхтний сэтгэлгээг бий болгож байна. Иймд улс хоорондын харилцаанд бий болсон түүхэн нөхцөл, эрин цагийн шинж байдалтай уялдан олон улсын бодлогод ч илүү ардчилсан шинжтэй чанарын дэвшил өөрчлөлт гарах хандлага нэгэнт илэрхий болжээ. Гэхдээ олон улсын харилцааны реалист онолын үнэ цэнэ түүний нөлөө хүчтэй хэвээр байна. Учир нь олон улсын амьдралд чанарын шинжтэй үлэмж өөрчлөлт гарч байгаа ч гэсэн мөн л олон зүйл өөрчлөгдөөгүй байна. Олон улсын харилцааны систем түүний шинж чанар нэг хэв төрхөөс нөгөөд шилжиж буй шилжилтийн үедээ явж байна. Иймд хүчний (Power) тухай үзэл баримтлалд түшиглэсэн Реалист онол нэг хэсэгтээ үйлчлэх нь дамжиггүй. Учир нь өнөөгийн олон улсын бодлогын өрнөл хөгжил нэг хэсэгтээ их гүрнүүдийн бодлогоос шууд хамаарна. Олон улсын харилцааны "шатрын хөлөгт" чухал нөлөө бүхий тоглогч байхын төлөөх их гүрэн, бүс нутгуудын өрсөлдөөн хүчтэй хэвээр байна. Тийм ч учраас хүчний төвүүд ойртон нэгдэж олон улсын бодлогод дөвүү хүч бололцоог бүрдүүлэхийг хичээх, түүнийг сааруулахын тулд эргээд хүчний тэнцвэр үүсгэх зэрэг үйл явцын мөчлөгүүд нэг хэсэгтээ үргэлжлэх төлөвтэй байна. Гэхдээ дэлхий ертөнц өөрийнхөө зүй тогтлоор алгуур хувьсан өөрчлөгдөж байна. Энэхүү хувьсал өөрөө олон улсын харилцааны шинж чанарыг мөн л өөрчлөн дагуулах жамтай. Энэ үнэнд гүйцэгдэхээс өөр аргагүй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Political Idealism, Political Realism, Liberalism, Socialist Internationalism
г.м.
2. Hans Morgenthau, Politics Among Nations. The struggle for Power and
Peace. N.Y. 1965 (4th ed) p.13-14.
3. Nghien cuu quoc te ,Hanoi, 1996 ,#14.
4. Comprehensive Security хэмээх нэр томъёог анх 70-аад оны
дундуур Японы Охирагийн Засгийн Газрын үед авч хэрэглэжээ.
Үүнийг дараа нь Зүүн Өмнөд Азийн АСЕАН-ы орнууд дэмжиж
хүлээн авсан юм.
5. John Stenbruner, The prospect of Cooperative Security, The Brookings
Review, Winter 1988/89.
6. David Dewilt and paul Evons, The Agenda for Cooperative Security in
the North Pacific: Conference Report, York University, NPCSD, 7-
1993
7. Pierre Lizee, Sorpong Peou, Cooperation Security and the emerging
security Agenda in Sautheast Asia: The challenges and opportunities
of Peace in Cambodia. Occasional Paper Number 21, CI SS, Canada,
9, 1993.
8. Tap chi "Nghien cuu quoc te" ,Hanoi, 1999 ,#28, p.55-62.